

а/ Аймгийн аж үйлдвэр, барилгын салбарын үүсэл хөгжил, танилцуулга

Манай аймаг анх 1942 онд байгуулагдаж жилдээ 562.6 мянган төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг барилгын , оёдлын 2 артель бүхий үйлдвэр хоршооллын артель, цөцгийн тос боловсруулах завод 4, талхны цех зэрэг үйлдвэр үйлчилгээний салбар бүхий жилдээ 700 орчим мянган төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хүнсний үйлдвэр ажиллуулж байжээ.

2004-2007 онд манай аймгийн хувьд Цайрт минериал, Баянцогт мөнхийн гал гэх зэрэг тооцоохон уул уурхайн компаниуд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.

Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдэд аж ахуйн нэгж байгууллагуудад ажиллагчид, зардал, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, биет хэмжээ, үнийн дүнгээр, бүтээгдэхүүний борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүдийг оруулдаг.

Тэдгээр үзүүлэлтүүдийг гаргах мэдээллийн эх сурвалж нь үйлдвэрийн газруудын сар, улирал, жилийн тайлан, тооллого, судалгааны материал нь болдог.

2005 оноос эхлэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг 2000 оны зэрэгцүүлэх үнээр тооцож байна.

Аж үйлдвэрийн салбарын ангилал:

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ийн эдийн засгийн үйл ажиллагааны салбарын стандарт ангилал (III хувилбар)-ыг 1997 оноос эхлэн мөрдөж байна.

Хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ажил үйлчилгээ эрхлэдэг нэгжийг тэдгээрийн дотор мэдэгдэхүйц өндөр хувийн жинтэй бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээр нь үндсэн салбарт оруулдаг

Томоохон аж ахуйн нэгж байгууллагын товч танилцуулга.

Цайрт минерал ХХК

Монгол улсын “Метал Импекс” ХХК нь Төмөртийн овооны цайрын ордыг ашиглахад шаардагдах хөрөнгө оруулалтыг олох зорилгоор гадаадын олон пүүс компанитай идэвхитэй харьцаж ажилласны үр дүнд БНХАУ-н “Өнгөт төмөрлөгийн гадаад дахь барилга, зураг төслийн компани”–тай Монголын тал 49 хувь, Хятадын тал 51 хувь эзэмших, улмаар хөрөнгө оруулалтын зээлээ төлж дуусмагц уг хувь 50:50 болох нөхцөлтэйгөөр хамтран ажиллах гэрээ байгуулж, Монгол Хятадын

хамтарсан “Цайрт Минериал” ХХК-г үүсгэн байгуулсан түүхтэй. Уг компани нь 2005 оны 8 сарын 28-нд ашиглалтанд оруулан өдгөөг хүртэл үйл ажиллагаа нь тогтворжсон Монгол улсын томоохон уул уурхайн компани болсон байна.

Төмөртийн-Овооны цайрын уулын баяжуулах үйлдвэр нь ил уурхайн аргаар жилдээ 300 мянган тонн хүдэр олборлож, дунджаар 50 хувийн агуулга бүхий 70 мянган тонн цайрын баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай.

Олборлолт

4-11 сарын хооронд буюу дулааны улиралд ил уурхайн аргаар жилд дунджаар нэг сая м³ хөрс хуулж 350-400 мянган тонн хүдэр олборлож баяжуулах үйлдвэрт ороход бэлэн болгодог.

Боловсруулалт

Баяжуулах үйлдвэр нь БНХАУ, ОХУ, Герман, Швед, Солонгос улсуудын дэвшилтэт техник тоног төхөөрөмжийг ашиглан, цайрын сульфидийн хүдрийг хүдэр бэлтгэх, баяжуулах, усгүйжүүлэх гэсэн дамжлагтайгаар боловсруулж 50 хувийн агуулга бүхий цайрын баяжмал үйлдвэрлэдэг. Үйлдвэр нь өдөрт дунджаар 1100 тн хүдэр баяжуулдаг ба металл авалт дунджаар 95 хувьтай байна.

Борлуулалт

Үйлдвэрлэсэн баяжмалаа Сайншанд хүртэл авто замаар, цааш нь төмөр замаар тээвэрлэн экспортод гаргаж байна. Авто замын тээвэрт нийт 100 гаруй машин, 250 гаруй хүн хамрагдан ажилладаг.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй 452 ААН байгууллага байгаагийн 6.2 хувь болох 28 нь огт үйл ажиллагаа явуулаагүй байна. Үүнээс: 4 нь үйл ажиллагаа явуулаагүй, 11 нь түр зогсоогдсон, 6 нь бүрэн зогсоогдсон, 7 нь бусад шалтгаанаар ажиллаагүй байна. Нийт бүртгэлтэй ААНБ-ын 93.8 хувь болох 424 ААНБайгууллага нь үйл ажиллагаагаа явуулж байна.


Үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг салбарын ангиллаар нь авч үзвэл: ХАА-н салбарт 3.1 хувь, Уул уурхай, олборлох үйлдвэрт 0.9 хувь, Боловсруулах үйлдвэрт 1.9 хувь, Цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамжид 1.2 хувь, Барилгын салбарт 2.6 хувь, Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагааны салбарт 31.8 хувь, Зочид буудал зоогийн газарт 5.7 хувь, тээвэр агуулахын аж ахуй, холбоонд 2.4 хувь, Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаанд 2.6 хувь, үл хөдлөх хөрөнгө түрээс бизнесийн үйл ажиллагаанд 2.2 хувь, Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалд 11.8 хувь, боловсролын салбарт 8.2, Эрүүл мэндийн салбарт 13.9 хувь, Нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээнд 11.7 хувь нь нь тус тус үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр ААНБ-дын ажиллагчдын тоог бүлэглэж харуулбал:

1.9 ажиллагчидтай 315, 10-19 ажиллагчидтай 46, 20-49 ажиллагчидтай 48, 50 дээш ажиллагчидтай 15 аж ахуйн нэгж байгууллага тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо, эдийн засгийн үйл салбараар.

Үйлчилгээ	Аж ахуйн нэгж	Өөрийн хөрөнгийн үйлчилгээ	Аж ахуйн нэгжид ажиллагаа үзүүлэх үйлчилгээ	Өөрийн хөрөнгийн үйлчилгээ, аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ	Аж ахуйн нэгж	Аж ахуйн нэгжид ажиллагаа үзүүлэх үйлчилгээ	Өөрийн хөрөнгийн үйлчилгээ, аж ахуйн нэгжид ажиллагаа үзүүлэх үйлчилгээ	Аж ахуйн нэгжид ажиллагаа үзүүлэх үйлчилгээ	Өөрийн хөрөнгийн үйлчилгээ, аж ахуйн нэгжид ажиллагаа үзүүлэх үйлчилгээ
2005	261	2	5	3	6	8	5	2	
2006	355	2	7	5	6	87	7	9	
2007	394	2	7	3	8	102	12	6	
2008	385	4	8	5	8	110	20	9	
2009	424	4	8	5	11	135	24	10	

Үйлчилгээ	Аж ахуйн нэгжид ажиллагаа үзүүлэх үйлчилгээ	Өөрийн хөрөнгийн үйлчилгээ, аж ахуйн нэгжид ажиллагаа үзүүлэх үйлчилгээ	Аж ахуйн нэгжид ажиллагаа үзүүлэх үйлчилгээ	Өөрийн хөрөнгийн үйлчилгээ, аж ахуйн нэгжид ажиллагаа үзүүлэх үйлчилгээ	Аж ахуйн нэгжид ажиллагаа үзүүлэх үйлчилгээ	Өөрийн хөрөнгийн үйлчилгээ, аж ахуйн нэгжид ажиллагаа үзүүлэх үйлчилгээ
2005	38	9	47	34	49	37
2006	29	9	45	33	59	44
2007	30	13	47	36	62	51



Аймгийн нийт ажиллагсад 21800 байгаагийн 2.6 хувь нь уул, уурхай олборлох аж үйлдвэрт, 0.8 хувь нь боловсруулах аж үйлдвэрт, 2.4 хувь нь Цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамжид, 0.5 хувь нь барилгын салбарт ажиллагсад байна. Өнгөрсөн онтой харьцуулбал нийт ажиллагсадын тоо 4.3 хувь буюу 969-өөр цөөн байна.

Ажиллагсдын тоо салбарын ангилалар.


Үйлдвэр	Аж ахуй	Өдөө үйлдвэр, үйлдвэр	Аж ахуйн үйлдвэр	Өдөө үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр	Аж ахуй	Аж ахуйн үйлдвэр, үйлдвэр	Цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамж	Барилга, үйлчилгээ
2005	18652	0	0	0	9	1081	30	0
2006	24618	286	89	126	130	1463	67	180
2007	24752	513	71	115	160	1749	94	201
2008	22769	629	63	95	140	1875	103	198
2009	21800	573	164	529	111	1795	99	175

2009 онд аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн 114013.0 сая төгрөгт хүрсэн байна. Энэ нь ДНБ 2005 оныхоос 3.3 дахин өсч, 2006 оныхоос 14.1 хувиар, 2007 оныхоос 24.3 хувиар, 2008 оныхоос 2.3 хувиар тус тус буурсан тооцоо гарч байна.

Нэг хүнд ногдох ДНБ 2005 онд 617.8 мянган, 2006 онд 2378.5 мянган, 2007 онд 2719.5 мянган, 2008 онд 2921.6 мянган, 2009 онд 2073.0 төгрөг тус ногдож байна.

Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн эзлэх байр суурь / салбарын ангилалар /
/сая.төг/

Аж үйлдвэрийн салбар	2005	2006	2007	2008	2009
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	25 984.6	31 047.6	37 027.0	38 257.2	41 158.7
Аж үйлдвэр, барилга	1 591.6	93 673.6	103 404.6	56 569.4	48 227.5
Үйлчилгээ	6 574.0	7 960.9	10 084.6	21 811.3	24 512.8
Дүн	34 600.0	132 682.2	150 516.2	116 637.9	114 013.0




Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт нь 33904.0 сая төгрөг болж, 2005 оноос 9.9 дахин, 2008 оноос 99.3 хувиар өссөн гүйцэтгэлтэй байна. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 87.4 хувийг уул уурхай, олборлох үйлдвэр, 12.1 хувийг цахилгаан дулаан, эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, 11.5 хувийг ус хуримтлуулах түгээх үйл ажиллагааны салбарт тус тус үйлдвэрлэсэн байна. БНХАУ-д 2008 онд Хүрэн нүүрс 850.0 мянган тн, цайрын баяжмал 135.9 тн бүтээгдэхүүн экспортолж 69.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийж байсан бол 2009 онд 494.6 тн молибден, хүрэн нүүрс 14.5 мян.тн, Цайрын баяжмал 141.3 мян.тныг экспортолж 90.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн / 2000 оны зэрэгцүүлэх үнээр, сая.төг /

Аж үйлдвэрийн салбар	2005	2006	2007	2008	2009	2009/2008 %
Уул уурхай, олборлох	2569.8	11508.9	28669.5	30544.9	29635.1	97.0
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт	69.2	79.7	68	82.2	154.2	187.6
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах	610.0	604.4	2599.6	3252.5	4114.7	126.5
Ус хуримтлуулан түгээх үйл ажиллагаа	185.0	194.9	307.9	230.8	3899.2	1689.4
Бусад салбар	-	3.1	30.9	35.8	215.4	601.7
ДҮН	3434.0	12391.0	31675.9	34146.2	33904.0	99.3

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг 2000 оны зэрэгцүүлэх үнээр сүүлийн 5 жилээр графикаар харуулбал:




Аймгийн аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 2009 онд оны үнээр 101.9 тэрбум төгрөг болж, 2005 оныхоос 8 дахин буюу 89.2 тэрбум төгрөгөөр өсч, 2008 оныхоос 34.9 хувиар буюу 26.4 тэрбумаар өссөн үзүүлэлттэй байна. 2005 оныхоос уул уурхай 8.5 дахин буюу 87.1 сая төгрөгөөр, 2008 оныхоос 35.9 хувь буюу 26.1 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн / оны үнээр /

Аж үйлдвэрийн салбар	2005	2006	2007	2008	2009	2009/ 2008 %
Уул уурхай, олборлох	11644.4	105293.3	137962.7	72690.8	98775.1	135.9
Боловсруулах аж үйлдвэр	70.1	77.4	76.6	198.4	329.5	166.1
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах	921.1	1085.2	1118.7	2670.1	2837.5	106.3
Үүнээс: ус хуримтлуулан түгээх үйл ажиллагаа	91.5	138.3	283.2	217.8	222.1	102.0
ДҮН	12731.9	106604.7	139441.2	75559.3	101942.1	134.9

Дээрхи бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг 2009 оны борлуулалтаар бүтцээр нь авч үзвэл:



Гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2005 онтой харьцуулахад 2009 онд талх, нарийн боов, дулаан, нүүрс өсч, архи, цахилгаан үйлдвэрлэлт буурч, цайрын баяжмалыг, үйлдвэрлэж эхэлсэн байна. Харин өнгөрсөн онтой зэрэгцүүлбэл: талх, нарийн боов, дулаан, эсгий үйлдвэрлэлт өсч, нүүрс, блок, архи, цахилгаан цайрын баяжмал, замын хавтан үйлдвэрлэлт буурсан үзүүлэлттэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2005	2006	2007	2008	2009	2009/2008 %
Уул уурхай, олборлох аж үйлдвэр							
Нүүрс	мян.тн	46.7	38.5	68.7	113.1	60.9	53.8
Цайрын баяжмал	мян.тн	22.8	110.0	136.3	143.6	141.3	98.4
Боловсруулах үйлдвэрлэл							
талх	тн	35.6	49.9	63.1	79.2	109.0	137.6
нарийн боов	тн	15.0	18.7	26.7	40.4	68.4	169.3
Архи	мян.л	14.4	9.7	3.7	2.0	1.0	50.0
Блок	мян.ш	х	8.6	35.0	63.9	19.2	30.0
Замын хавтан	м2	х	250	2858.5	2000.1	1908.3	95.4
Барилгын ялуу	м3	х	0.2	-
Эсгий	мян.м	0.8	6.8	8*дах
Цахилгаан, дулаан, усан хангамж үйлдвэрлэл							
Цахилгаан	мян.кв.цаг	342.5	254.5	305.1	272.5	248.1	91.0
Дулаан	мян. гкал	50.2	50.0	60.6	67.1	77.5	115.5


2.Барилга: Бизнес регистрийн санд бүртгэлтэй барилгын үйл ажиллагаа явуулж байгаа 10 ААН байгууллага байна. Аймгийн хэмжээнд 1750.2 сая.төг-ийн барилга угсралт, их засварын ажил хийсэн нь өнгөрсөн оноос 50.7 хувиар буурч, 2005 оныхоос 7.3 дахин буюу 1510.3 мянгаар өссөн байна. 2009 онд 17 барилга байгууламж ашиглалтанд оруулсан нь өнгөрсөн оноос 30.8 хувь буюу 4 өөр олон байна. Нийт ашиглалтанд орсон барилга байгууламжийг зориулалтаар нь авч

үзвэл: Орон сууцны барилга 361.4 сая төг, эмнэлгийн барилга 291.5 сая, конторын барилга 23.0, Эрчим хүчний шугам 309.5 сая, бетон гүүр 50.0 сая, явган зам 260.8 сая төгрөгөөр тус тус баригджээ. Үүнээс: их засварын ажилд нийт хөрөнгө оруулалтын 31.6 хувь болох 553.8 сая төгрөг зарцуулагдсан байна.

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл /сая.төг/

Үзүүлэлт	2005	2006	2007	2008	2009	2009/ 2008
Барилга угсралт их, засварын ажил	239.9	572.4	736.9	3449.6	1750.2	50.7
Ашиглалтанд оруулсан барилга, байгууламж	7	9	9	13	17	130.8

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг сүүлийн 5 жилийн байдлаар графикаар харуулбал:



Барилгын салбарын ДНБ үйлдвэрлэлт нь 2005 оныхоос 7.3 хувиар, 2006 оныхоос 3.1 хувиар, 2007 оныхоос 2.4 хувиар тус тус өсч, өнгөрсөн оноос 29.5 хувиар буюу 179.2 сая төгрөгөөр буурчээ. Аймгийн нийт ДНБ-ний 0.4 хувийг барилгын салбар эзэлж байна.

Аймгийн нийт ажиллагсдын 0.6 хувь нь барилгын салбарт ажиллаж байна.

Барилгын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт. /сая.төг/

Үзүүлэлт	Нэмэгдэл өртөг				2009/ 2008
	2005	2006	2007	2008	
Барилга	144.5	261.3	607.5	428.3	70.5
Аймгийн дүн	42 958.2	132 681.3	156 975.1	116 637.9	74.3

б/ Тухайн аймгийн нутаг дэвсгэр дээр худалдааны үйл ажиллагаа явуулах, орчин нөхцөл бололцоо.

Сүхбаатар аймаг нь Монгол орны зүүн өмнөд хэсэгт 82.3 хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэрийг эзлэн, урд талаараа БНХАУ, баруун талаараа Дорноговь , баруун хойт талаараа Хэнтий, зүүн талаараа Дорнод аймагтай тус тус хиллэдэг.

Аймаг 2009 онд 15.2 мянган өрх, 54.4 мянган суурин хүн амтай болсон бөгөөд нийт өрхийн 3.2 хувь буюу 4.8 мянган өрх аймгийн төвд амьдарч байна.

Нийт хүн амын 51.2 хувь нь хөдөө, 48.8 хувь нь аймаг сумын төвд амьдарч байгаа ба 64.8 хувь нь 16-59 насны хөдөлмөрийн насны хүн байна.

3. Худалдааны салбарын үүсэл хөгжил ба өнөөгийн байдал

Худалдааны салбарт 130 ААНБайгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тус салбарт 385 орчим хүн ажиллаж байгаа нь аймгийн нийт ажиллагсдын 8.2 хувийг эзэлж байна.


Худалдааны графикт мэдээнд хамрагдаж үйл ажиллагаа явуулж байгаа 21 Аж ахуйн нэгж байгууллагад 56 хүн ажиллаж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс ажиллагсдын тоо 49.1хувь буюу 54 хүнээр буурч байна.

Нийт борлуулалтын орлого 1812.7 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 18.1 хувиар буюу 401.0 мянган төгрөгөөр буурсан гүйцэтгэлтэй байна. Нийт орлогыг үйл ажиллагааны төрлөөр нь авч үзвэл: шатахуун борлуулалтын орлого 2.2 хувь, эм гоо сайхны бараа 4.4 хувь бусад төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа 93.4 хувийг эзэлж байна. Энэ салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААН байгууллагын 28.6 хувь хамрагдаж байна.

Худалдааны салбарын гүйцэтгэл сонгогдсон /ААНБ/-аар

Үзүүлэлт	Нийт орлого /мян.төг/				Ажиллагсдын тоо				Мэдээлэлд хамрсан байгууллага		
	2006	2007	2008	2009	2006	2007	2008	2009	2006	2007	2008
Шатахууны жижиглэн худалдаа	119.3	118.3	115.8	39.0	6	8	7	10	2	2	2
Эм, гоо сайхны барааны жижиглэн худалдаа	77.5	92.8	130.9	79.4	9	12	13	17	2	2	2
Бусад төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа	848.7	1 550.5	1 967.0	1694.3	31	100	90	29	19	40	40

Худалдааны салбарын гүйцэтгэлийг графикаар харуулбал:



4. Холбооны үйлчилгээний орлого радио телефон цэгийн тоо

Холбооны нийт орлого,үүнээс хүн амаас орсон орлого телефон болон радио цэгийн тоо зэрэг үндсэн үзүүлэлтийг харуулав.

Нийт орлого Холбооны үйл ажиллагааны нийт орлого гэдэгт цахилгаан холбоо,хөдөлгөөнт холбоо,мэдээллийн технологи,шуудангийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж,байгууллагуудын тайлант хугцааны нийт орлогыг оруулна.

Үүрэн телефон хэрэглэгч Тухайн байгуулсан сүлжээний хүрээнд хөдөлгөөнтэй /нэгээс нөгөө үүрт шилжих/ашиглах боломжтой утасгүй холбооны хэрэглэгч юм.

Утасгүй холбооны хэрэглэгч Тухайн байгуулсан сүлжээний хүрээнд ажиллах радио долгионы холбооны хэрэглэгч .


Интернет кафе Олон нийтэд нэг цэгт интернет үйлчилгээ үзүүлэгч байгуулагаа аж ахуйн нэгж

2009 онд 243.5 сая.төг болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 30 хувь буюу 104.6 сая төгрөгөөр буурсан байна. Хүн амаас орох орлого нь нийт орлогын 33.9 хувийг эзэлж байна.

Холбооны салбарын үзүүлэлтүүд / оноор /

Үзүүлэлт	хэмжих нэгж	2005	2006	2007	2008	2009
Нийт орлого	сая.төг	483.9	520.1	521.9	348.1	243.5
Хүн амаас орох орлог	сая.төг	250.3	281.5	273.4	148.3	82.7
Телефон цэг	ш	1527	1512	1527	1422	1090.0

Холбооны салбарын гүйцэтгэлийг графикаар харуулбал:



Суурин телефон цэгийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 23.4 хувь буюу 332-оор буурсан байна. Сүүлийн жилүүдэд үүрэн телефон хэрэглэгчдийн тоо эрс өсч байна.

Тус аймгийн иргэд, хөдөлмөрчид Ньютел, Скайтель, Юнитель, Жи мобайл зэрэг үүрэн телефоны хэрэглэгч болсноор холбооны орлого болон суурин телефон хэрэглэгчийн тоо буурах хандлагатай болж байна. Тээвэр холбооны салбарт аймгийн нийт ажиллагсдын 0.9 хувь нь буюу 198 хүн ажиллаж байна.

5.Тээврийн салбарын тээсэн ачаа,зорчигчдын тоо,ачаа эргэлт,зорчигч эргэлт

Тээврийн салбарын статистик үндсэн үзүүлэлтүүд ачаа эргэлт,тээсэн ачаа,зорчигч эргэлт,авто машины тоо,шилжүүлсэн тонн,км ажиллагсдын тоо орлого зэрэг орно .Авто тээврийн статистик мэдээ тайланг аж ахуйн нэгжүүдээс аймгийн статистикийн хэлтэс цуглуулан авч нэгтгэн Үндэсний статистикийн хороонд дамжуулдаг,

Ачаа эргэлт Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг зөөвөрлөсөн зайгаар үржүүлсэн үзүүлэлт

Зорчигч эргэлт Нийт зорчигчдын тоог тээвэрлэсэн зайгаар үржүүлсэн хэмжээ


Шилжүүлсэн тонн км Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл хэлбэрийн ажил үйлчилгээг тусгай коэффицентийг ашиглан нэг нэгжид шилжүүлж тооцно.

Тээвэр бүхий байгууллагууд 2009 онд 188.2 мян.тн ачаа тээвэрлэж, 13.6 мян.хүн тээвэрлэж, ачаа эргэлт 54874.6 мян.тн.км, зорчигч эргэлт 7210.0 мян.хүн.км-ийн ажил гүйцэтгэж, нийт орлого 6603.8 сая төгрөгт хүрлээ. Тээсэн ачаа 2005 оныхоос 9.2 дахин, 2009 оныхоос 25.8 хувиар буюу 38.6 мян.тн-оор, зорчигчдийн тоо 9.8 хувь буюу 0.3 мян.хүнээр буурч 2009 оныхоос 8.5 мян. хүнээр 2005 оноос тээсэн ачаа 7.3 дахин буюу 129.1 мян.тн-оор, зорчигчдийн тоо 1.6 дахин буюу 8.2 мян.хүнээр тус тус өссөн гүйцэтгэлтэй байна. Тээврийн байгууллагын тээсэн ачаа, ачаа эргэлтийн эдийн засгийн үзүүлэлт буурч байгаа нь тус аймагт Цайрын баяжмалыг гадны байгууллагаар гүйцэтгэх болсонтой холбоотой юм. Гэхдээ тээврийн зонхилох орлогыг Цайрт фрейд ХХК оруулдаг бөгөөд нийт орлогын 90.7 хувь буюу 5987.9 сая төгрөгийн орлогыг оруулсан байна.

Тээврийн салбарын гүйцэтгэл

Үзүүлэлт	хэмжих нэгж	2005	2006	2007	2008	2009	%
Тээсэн ачаа	мян.тн	20.5	187.6	194.9	149.6	188.2	125.8
Ачаа эргэлт	мян.тн.км	466.2	3 005.8	5 505.4	42 141.2	54 874.6	130.2
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	13.9	19.4	25.6	22.1	13.6	61.5
Зорчигч эргэлт	мян.хүн.км	6 425.6	10 119.0	12 356.0	8 853.8	7 210.0	81.4
Тээврийн орлого	сая.төг	55.8	74.9	275.9	5 922.0	6 603.8	111.5

Тээврийн салбарын гол үзүүлэлт болох тээсэн ачаа, зорчигч тээвэрлэлтийг графикаар харуулбал:




Манай аймгийн хэмжээнд авто техникийн 2009 оны улсын үзлэгээр бүх төрлийн авто машин нийт 3.4 мянга болсны 53.4 хувь буюу 1.8 мянга нь суудлын авто машин, 79.9 хувь буюу 1.5 мянга нь ачааны, 1.7 хувь буюу 0.01 автобус, 1.5 хувь буюу 0.01 мянга нь тусгай зориулалтын авто машин байна. Нийт авто машиныг ашиглагдсан хугацаагаар ангилж авч үзвэл: 45.3 хувь буюу 1551 машин нь 10 хүртэлх жил 24.8 хувь буюу 851 машин нь 10-аас дээш жил ашиглагджээ. Хувийн хэвшлийн 2455 машин үзлэгт хамрагдсан нь нийт авто машины 93.3 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оноос 7.3 хувиар авто машины тоо өсчээ.

Улсын үзлэгийн дүнтэй харьцуулбал: нийт авто машины тоо 1.5 хувийг эзэлж байна.

Авто машины тоо /төрлөөр/

Үзүүлэлт	2005	2006	2007	2008	2009	төрлөөр				
						суудлын ачааны	Ачааны	автобус	цистерн	тусгай зориула
Авто машины тоо	1883	2215	2 452	2 632	3 427	1 830	1 462	57	25	53
Улсын дүн	131184	140872	161 989	190 459	224 068	153 906	47 291	16 136	2 028	4 707



Дүгнэлт, санал

Манай аймгийн хувьд уул уурхайн салбарын “Цайрт минериал”, “Баян цогт мөнхийн гал” зэрэг томоохон компаниуд үйл ажиллагаагаа явуулж эхэлснээр борлуулалт, бүтээгдэхүүний нэр төрөл, биет хэмжээ нэмэгдсэнээс гадаад дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх байр суурьд ихээхэн өөрчлөлт орсон. Дотоодын нийт бүтээгдэхүүний 42.3 хувь болох 48.2 тэрбум төгрөгийг уул уурхай, олборлох үйлдвэр бүрдүүлж байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2073.0 мянган төгрөг болж байна.

Аймгийн худалдаа, үйлчилгээний салбарт бизнесийн таатай орчин бүрдэж, бизнес эрхлэж амьдрал ахуйгаа дээшлүүлж байгаа иргэдийн тоо нэмэгдэж, ард иргэдийн амьдрал дээшилж байгаа бөгөөд манай аймгийн худалдааны салбарт нөлөөлөх нэг давуу тал нь БНХАУ-тай хөрш зэргэлдээ оршиж худалдаа наймаагаа хөгжүүлж байгаа явдал юм. Тухайн аймгийн худалдааны салбарын нийт орлого жил ирэх тутам өсч байгаа нь манай хувийн хэвшилд ажиллаж байгаа иргэд, бизнес эрхлэгчдийн маань хүчин зүтгэл, мөн банкны байгууллагуудын жижиг бизнес эрхлэгчдийг дэмжиж олгож байгаа зээл, бөөний сүлжээний төв байгуулж төсөл хэрэгжүүлж ажиллаж байгаа нь нөлөөлж байна.

Энэ онд манай аймагт тээвэр авто замын газар байгуулагдсан нь тээврийн салбарын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах таатай орчинг бүрдүүлж эхлээд байна.

Тус аймгийн тээврийн салбарын дийлэнх хэсэг нь хувьчлагдаж, хувийн тээврийн үйлчилгээ зонхилж байгаа бөгөөд тээврийн ачаа болон зорчигч тээврийн орлого үйлчилгээний хэмжээ өссөн үзүүлэлтэй байна.

Холбооны салбарын хувьд түлхүү хөгжиж ирсэн нь харагдаж байна. Тус аймаг шилэн кабелийн сүлжээнд холбогдож, техник технологийн шинэчлэлт хийсэн нь олон давуу талыг харуулж байна. Гэвч холбооны салбарын эдийн засгийн үзүүлэлт жил ирэх тутам унаж байна.

Үүрэн телефоны операторууд манай аймагт иргэд хөдөлмөрчдийн хэрэгцээг хангаж ажиллаж байгаа нь нэг талаар сайн үзүүлэлт боловч, зах зээлийн өрсөлдөөн ихтэй, төвдөө төвлөрсөн удирдлагатай тайлан баланс гардаггүй гэдгээр манай статистик мэдээлэлд хамрагдах боломжгүй байдаг нь бидний хувьд ямарч мэдээлэл дүгнэлт байдаггүй нь дутагдалтай.

Хойшид үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээрхи санал:

- Шинээр худалдааны чиглэлээр бий болж байгаа ААН Байгууллагууд онцгой зөвшөөрөл авахын тулд 1-2 хүний бүрэлдхүүнтэй ХХК болж үүсч байгаа нь

санхүүгийн талаар ямар ч мэдэгдэхүүнгүй нэг гэрийн хоёр хүн дарга, нягтлан гэж бүртгүүлснээс статистикийн мэдээ тайлан гаргах, АШБ хөтлөх талаар ямар ч ойлгоцгүй байна. Иймд ААН Байгууллага шинээр бий болоход тодорхой босго тавьж өгөх шаардлага гарч байна.

- Манай статистикийн мэдээний хугацаатай холбооны мэдээлэл таардаггүй нь мэдээний гүйцэтгэл бүрэн хамралттай орж чаддаггүй дутагдал сүүлийн жилээс гарч байна. Иймд Монголын цахилгаан холбоотой мэдээний графикаа зохицуулалт хийх
- Үүрэн телефоны операторууд манай аймагт иргэд хөдөлмөрчдийн хэрэгцээг хангаж ажиллаж байгаа нь нэг талаар сайн үзүүлэлт боловч, зах зээлийн өрсөлдөөн ихтэй, төвдөө төвлөрсөн удирдлагатай тайлан баланс гардаггүй гэдгээр манай статистик мэдээлэлд хамрагдах боломжгүй байдаг Хойшид үүрэн телефонууд аймагтаа нэгдмэл удирдлаган дор мэдээлэлд хамрагдаж байх нь хуулийн заалтад нийцэх юм.
- Манай аймагт бүртгэлтэй хотоос үйл ажиллагаагаа удирдаж явуулж байдаг тээврийн компани байна. Энэ компанийн мэдээллийг оршин байгаа дүүргийн статистикийн хэлтсээр авахуулж авч болох эсэх.

Энэхүү судалгааны хамрах хугацаа нь 2005, 2006, 2007, 2008, 2009 оны гүйцэтгэлээр харууллаа.

Ашигласан материал:

Жилийн эцсийн мэдээ, тайлан

ДНБ-ний тооцоо улс, аймаг, он он оны статистикийн эмхтгэл

Хүн ам өрхийн бүртгэлийн сангийн үзүүлэлт зэргийг ашиглав.

Танилцуулга бичсэн

Ц.Хад